

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2017 ОН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Засаг даргаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн аймгийн 2018 оны төсвийн төсөлд санал оруулж байна.

Төсвийн тухай хуулийн 8.5.1¹ дүгээр заалт болон Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу аймгийн Засаг даргаас Дундговь аймгийн 2018 оны төсвийн төслийг боловсруулан 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлжээ.

Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.3²-т зааснаар аймгийн Засаг дарга Дундговь аймгийн 2018 оны төсвийн төслийг Төрийн аудитын газарт 11 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлэхээр тусгасан боловч улсын төсөв 11 дугаар сарын 14-ны өдөр батлагдсантай холбоотойгоор 2017 оны 11 дүгээр сарын 25-нд урьдчилсан байдлаар ирүүлж, 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт”-ыг 2017 оны 11 дугаар сарын 29-ний өдөр эцэслэж Төрийн аудитын газарт ирүүлсэн зэргээс шалтгаалан 2018 оны төсвийн төсөлд өгөх саналыг богино хугацаанд боловсрууллаа. Түүнчлэн төсвийн орлого, зардлын төлөвлөлтийн талаарх зарим дэлгэрэнгүй судалгаа, нарийвчилсан тооцоог бүрэн ирүүлээгүй нь санал боловсруулахад хүндрэлтэй байсан.

Аудитын газраас аймгийн 2018 оны төсвийн төсөлд санал боловсруулахдаа зарим бодитой хэрэгжих орлогыг өмнөх оны түвшингээс бууруулахгүй байх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар зарчмын санал дэвшүүлэхийг зорьсон болно.

¹ 8.5.1.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

²Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны төсвийн төслийг аймаг, нийслэлийн аудитор, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Дундговь аймгийн 2018 оны төсвийн төсөлд болон 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр эдийн засаг, санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд хэрхэн тусгагдсаныг авч үзвэл:

- Дундговь аймгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл эхний 10 сарын байдлаар 101.3 хувь буюу 3,834.3 сая төгрөг байна. 2017 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн 14 нэр төрлийн орлого 391.7 сая төгрөгөөр тасарсан байна.
- Аймгийн 2018 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн суурь орлогыг 6,088.4 сая төгрөг, суурь зарлагыг 11,494.3 сая төгрөг, суурь зарлагаас санхүүжих орон нутгийн хөрөнгө оруулалтад 1,661.2 сая төгрөг, дээд шатны төсвөөс 7,310.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар тооцоолжээ.

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвөөс шилжүүлэх тусгай шилжүүлгийн орлого, зарлагыг 24,608.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлого, зарлагыг 2,155.3 сая төгрөг байхаар тус тус тооцсон байна.

Хоёр. Орон нутгийн төсвийн орлого

2.1.Үндсэн мэдээлэл

Дундговь аймгийн 2018 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг нийт 5,796.3 сая төгрөг байхаар Сангийн яамнаас тооцсоныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас 6,088.4 сая төгрөг болгон суурь орлогыг 292.1 сая төгрөг буюу 4.8 хувиар нэмэгдүүлсэн байна. Нэмэгдүүлсэн орлого болон урьд оны үлдэгдэл, хандив тусламжийн орлогын дүнг нэр төрлөөр харуулбал:

- Урьд оны үлдэгдэл 15.0 сая төгрөг,
- Хандив тусламжийн орлого 18.5 сая төгрөг,
- Хөрөнгө борлуулсаны орлого 35.0 сая төгрөг,
- Газрын дуудлага худалдаанаас орох орлого 35.0 сая төгрөг,
- Татварын бус орлого буюу төсөвт байгууллага, тусгай шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого 188.5 сая төгрөг.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас 2018 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг нийт 6,088.4 сая төгрөг байхаар тооцсоны 5,497.5 сая төгрөг буюу 90.2 хувийг татварын орлогоор, 590.9 сая төгрөг буюу 9.8 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр тусгасан байна.

2.2. Төсвийн төсөлд өгөх санал

Аймгийн 2018 оны төсвийн төсөлд орлогын дараах саналыг боловсруулан хүргүүлж байна.

/сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	2018 оны төсвийн төсөл	Аудитын санал
1	Хог хаягдлын үйлчилгээ	29.6	23.8	63.4%	55.0	Орлогыг бүрэн төвлөрүүлэх
2	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	21.0	17.7	82.6%	28.0	Орлогыг үндэслэлтэй төлөвлөх
3	Газрын төлбөр	190.0	180.0	93.2%	180.0	Бүрэн ногдуулж, төсөвт төвлөрүүлэх
4	Дулаан үйлдвэрлэгч компаниудаас орон нутгийн өмч ашигласны түрээс				47.0	Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор түрээс тооцож шугамын засвар үйлчилгээний сан байгуулах

1. Хог хаягдлын үйлчилгээ:

2017 онд хог хаягдлын үйлчилгээний орлогыг 45.0 сая төгрөгөөр батлаад, аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 05 тоот тогтоолоор 15.4 сая төгрөгөөр хасч тодотгосон байна. Эхний 10 сарын гүйцэтгэлээр 15.4 сая төгрөгийн орлого төвлөрч 52.0 хувийн биелэлттэй байна.

Иймд Засгийн газрын хог хаягдлын норматив тогтоох, төлбөр тооцох аргачлалын дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 55 дугаар тогтоолоор баталсан “Дундговь аймагт мөрдөх хог хаягдлын төлбөрийн жишиг үнэ”-ийн дагуу төлбөрийг тооцон, түүний хэрэгжилтэнд холбогдох албан тушаалтнууд хяналт тавин ажиллах шаардлагатай байна. Төсвийн төсөлд санал өгөх явцад судалгаа, тооцооллыг 2016 оны жилийн эцсийн статистикийн мэдээллээр зөвхөн өрх, хүний тоонд тулгуурлаж тооцоолол хийхэд $хүний\ тоогоор\ 45515 \times 3300 = 150.2\ сая\ төгрөг$, $айл\ өрхөөр\ 14128 \times 3300 \times 5\ кг = 233.1\ сая\ төгрөг$ болж байна.

Мөн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын дагуу өөр олон боломж байгааг дурдах нь зүйтэй.


Дээрх жишиг үнээр аймгийн нийт хүн амд хог, хаягдлын үйлчилгээний хураамжийг тооцсон тооцоололоос харахад 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан 55.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө биелэхээр харагдаж байна. Иймд Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-т /нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын

тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих/ 9.1.2-т /хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих/ гэж заасны дагуу аймаг сумдын ИТХ, Засаг дарга нар эрх үүргээ хэрэгжүүлэх талаар шат шатандаа анхаарч, хураамжийг ногдуулах, төвлөрүүлэх арга хэлбэрийг оновчтой байдлаар зохион байгуулбал дээрх орлогын төлөвлөгөө бүрдэх боломжтой гэж үзлээ.


2.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр:

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 2015 оноос бусад онд буюу 2014 онд 11.8 сая төгрөг, 2016 онд 14.4 сая төгрөгөөр тус тус тасарч, 2017 оны 10 дугаар сарын байдлаар 3.2 сая төгрөгөөр дутуу биелэлттэй, орлогын төлөвлөгөө тасрах хандлагатай байна.

Графикаар харуулбал:



2015 онд түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө биелсэн нь орлогын төлөвлөгөөг тодотгосонтой холбоотой байна.



Сүүлийн 5 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад жилээс жилд орлогын гүйцэтгэл буурсан байна. 2017 онд түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрийг 52.0 сая төгрөгөөр батлагдсаныг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 05 тоот тогтоолоор 31.0 сая

төгрөгөөр хасч тодотгон, 21.0 сая төгрөг болгосон нь жилийн эцсийн гүйцэтгэлийн мэдээгээр биелэх боломжтой болсон байна.

2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хууль батлагдаж, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д /*Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно.*/, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д /*аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах* / гэж заасны дагуу арга хэмжээ зохион байгуулан ажиллах нь зүйтэй байна.

Ингэснээр тус хуулийн 33 дугаар зүйлийн 3.1³, 33.2⁴-т заасны дагуу заасны дагуу ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2.5 хувьтай тэнцэх төлбөрийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлбэл 2018 онд төлөвлөгдсөн орлого бүрэн биелэх боломжтойгоос гадна орлого нэмэгдэхээр байна.

3.Газрын төлбөр:


2017 онд газрын төлбөрийн орлогыг 190.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд эхний 10 сарын байдлаар 146.8 сая төгрөгийн орлого төвлөрөхөөс гүйцэтгэлээр 136.8 сая төгрөгийн орлого төвлөрч, 93.2 хувийн биелэлттэй буюу жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэл 94.7 хувийн биелэлттэй 53.2 сая төгрөгөөр тасрах хандлагатай байна.

2018 оны төсвийн төсөлд орлогын хэмжээг 180.0 сая төгрөг буюу өмнөх оноос 10.0 сая төгрөгөөр бууруулан тусгасан байна.

³ 3.1-т /Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө/

⁴ 33.2-т /Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2.5 хувьтай тэнцүү байна/

/сая төгрөгөөр/



Газрын төлбөрийн орлогын биелэлтийг сүүлийн 6 жилийн байдлаар авч үзэхэд орлогын төлөвлөгөө сүүлийн дөрвөн жил дараалан тасарч, 2017 оны байдлаар ч тасрах хандлагатай байна.

Орлогын төлөвлөгөө биелэхгүй байгаа нь хуульд заасан газрын төлбөр ногдох зүйлд ногдуулалтыг бүрэн хийдэггүй, ногдуулсан татварыг бүрэн төлөхгүй байгаатай холбоотой байна. Энэ талаар 2017 оны төсвийн төсөлд өгсөн саналд оруулсан боловч хэрэгжээгүй байна.

Тухайлбал:

- Зам, шугам сүлжээ буюу шилэн кабелийн газарт төлбөр ноогдуулахгүй байна. Энэ нь Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д “Газрын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан зам, шугам сүлжээний газрын километр тутмаас”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-д “зам, шугам сүлжээний газрын километр тутмын газрын төлбөрийн доод хязгаар 1500 төгрөг, дээд хязгаар 7500 төгрөг”, /615 км*1500=922.5 / үүнийг холбооны газраас авсан/ Газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэхгүй байна.
- Мал бүхий иргэдэд бэлчээрийн төлбөр бүрэн ногдуулахгүй байгаа нь Газрын төлбөрийн тухай хуулийн 6.1.1-д “бэлчээрийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрийг уг бэлчээрийн нэгж талбайн суурь үнэлгээний хувиар хонин толгойд шилжүүлсэн малын толгой тутамд ноогдуулж авна” гэж заасантай нийцэхгүй байна.

4. Газрын дуудлага худалдаа:

Аймгийн 2018 оны төсвийн төсөлд газрын дуудлага худалдааны орлогыг Сангийн яамнаас өмнөх оны түвшингээр тооцож ирүүлсэн байсан ч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 35.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 85.0 сая төгрөг болгосон байна. 2017 онд 50.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас

эхний 10 сарын байдлаар 14.9 сая төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 29.8 хувьтай байна.

2013-2016 оны газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулсан судалгаа хийхэд дараах байдалтай байна.

					/сая төгрөг/
Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017 оны 10 сар
Төлөвлөгөө	40.0	50.0	100.0	50.0	50.0
Биелэлт	2.1	101.7	27.3	58.6	14.9
Хувь	5%	203%	27%	117%	29.8%

Судалгаанаас харахад 2013 онд орлогын төлөвлөгөө бага дүнтэй төлөвлөсөн боловч биелээгүй харин 2014 онд төлөвлөгөө 203.3 хувьтай биелсэн нь 2014 оноос өмнө газрын дуудлага худалдаа зохион байгуулаагүй, газрын анхны үнийг авдаггүй байсантай холбоотой байна.

Тухайлбал 2014 онд аймгийн дүнгээр нийт 67 байршилд 22.37 га газрыг дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр газрын анхны үнийг төлүүлэх замаар эзэмшүүлжээ.

2015 онд сумдад дуудлага худалдаа огт хийгдээгүй, аймгийн төвд 3 удаагийн дуудлага худалдаагаар нийт 0.56 га газрыг 2 иргэн, 1 аж ахуй нэгжид эзэмшүүлсэн.

2016 онд 4 байршилд газрын дуудлага худалдаа зохион байгуулж, 3 байршлын газрын дуудлага худалдаа амжилттай болж, орон нутгийн орлогод 3.3 сая төгрөгийг төвлөрүүлж, 1 байршилд бүртгүүлсэн иргэн, аж ахуй нэгж гараагүй тул дуудлага худалдаа болоогүй байна.

2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газраас аймгийн Засаг даргын захирамжаар 37 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 6.59 га газрыг шинээр эзэмшүүлж газрын дуудлага худалдаа болон суурь үнээс 55.3 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Мөн 2016 онд Дэлгэрцогт суманд сумын Засаг даргын захирамжаар 3 байршилд 0.15 га газар дуудлага худалдаа зарлаж сумын төсөвт 2.8 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

2017 оны 10 сарын байдлаар газрын дуудлага худалдааны орлого 14.9 сая төгрөг буюу 29.6 хувийн биелэлттэй байна. Энэ нь дуудлага худалдааг сумдад зохион байгуулаагүй, Сайнцагаан суманд 6 удаа зарласан боловч оролцогч бүртгүүлээгүйтэй холбоотой байна.

Цаашид төв замд холбогдсон Дэлгэрцогт, Хулд, Луус зэрэг сумд газрын дуудлага худалдаа явуулж, суурь үнийг нэмэгдүүлэх боломжтой. Мөн сумдын тухайн жилд эзэмшүүлж, ашиглуулж байгаа газрын суурь үнийг бүрэн төлүүлэх шаардлагатай байна.

5. Түрээсийн орлого:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор 2017 онд батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх” журмын 1.2-т /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 5-д зааснаас бусад орон нутгийн өмчийн бүх төрлийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлж болно/ заасны дагуу дулаан үйлдвэрлэгч компаниудаас орон нутгийн өмч болох дулааны шугамын хэмжээнд түрээс ногдуулж шугамын засвар үйлчилгээ зарцуулах санг бий болгох хэрэгтэй байна.

“Ган-Илч” ХХК, “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ийн ашиглаж байгаа шугамын уртаар тооцож тооцооллыг хийсэн болно. “Тэвшийн говь” ХХК-н мэдээллийг ОНӨГ-аас шаардсан боловч ирүүлээгүй.

Тооцооллоор: Дээрх аж ахуй нэгжүүдийн ашиглаж байгаа шугамын нийт урт 6112.13 м байна. $6112.13 \text{ м} * 5.5 \text{ мянган төгрөг} * 7 \text{ сар} = 235.3 \text{ сая төгрөг}$ болж байна. Үүний 80 хувийг эрсдэлд тооцоод 20 хувийг түрээсийн орлого болгон тооцох боломжтой гэж үзвэл 47.0 сая төгрөгийн санг үүсгэх боломжтой байна.

Гурав. Орон нутгийн төсвийн зарлага

Дундговь аймгийн 2018 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 11,494.3 сая төгрөг байхаар тооцсон нь 2017 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 4.7 хувь буюу 542.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн зардлын сүүлийн 6-н жилийн төлөвлөгөөг харьцуулж үзэхэд зардлын төлөвлөгөө 2010-2014 он хүртэл тогтмол өсөлттэй байснаа 2015 онд 53.6 сая төгрөгөөр, 2016 онд 403.9 сая төгрөгөөр, 2017 онд 783.6 сая төгрөгөөр тус тус буурч, 2018 оны төсвийн төсөлд 542.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.



Аймгийн 2018 оны төсвийн төсөлд өмнөх оны дүнгээс бараа үйлчилгээний бусад зардлыг 23.3 хувь, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллыг 100 хувиар тус тус бууруулах, харин үндсэн цалинг 8.2 хувь, байр ашиглалтай холбоотой

тогтмол зардлыг 5.5 хувь, томилолт зочны зардлыг 27.3 хувиар тус тус нэмж батлахаар төлөвлөжээ.

Дөрөв. Хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр цаашид судалж шийдвэрлэвэл зохих асуудлын талаар

Асуудал 4.1: Хөрөнгө оруулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын талаар:

2018 онд Төсвийн тухай хуулийн дагуу Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д 1,257.2 сая төгрөг, сумдын ОНХС-д 898.1 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдахаар төсөв батлагдсан байна.

2018 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Төсвийн тухай хууль, холбогдох журамд нийцсэн эсэхийг хянаж аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхэд хууль журмын хувьд зөрчилтэй ажлын жагсаалтыг дараах хүснэгтээр харууллаа.

№	Өгөгдөл	Төсөвт өртөг /сая төгрөгөөр /	Тайлбар	Зөрчигдсөн хууль, журмын заалтууд
1.	Зүүн бүсийн сум дунд эрүүл мэндийн төвийн ажилчдын сууц	55.5	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх боломжтой, Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын иргэдээс авсан саналаар дэмжигдээгүй, Зураг, төсөв хийгдээгүй	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д /тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр санхүүжүүлнэ/, 6.6.2-т /төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байна/, 60.3.6-д /Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй зардал арга хэмжээнд зарцуулахыг хориглоно/, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журмын 6 дугаар

				зүйлийн 6.3.3.-т /хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх/
2.	Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, гадна цэвэр усны ажил	50.0	Иргэдийн саналаар дэмжигдсэн боловч төсөв хийгдээгүй	Төсвийн тухай хуулийн дүгээр зүйлийн 29.4.-т /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана./
3.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	150.0	Төсөв хийгдээгүй.	2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журмын 6 дугаар зүйлийн 6.3.3.-т /хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх/
4.	Зураг төсөв	78.2	Ямар ажлуудын зураг төсөв хийгдэх нь тодорхой бус	
	ОНХС-ийн дүн	333.7		
Орон нутгийн хөрөнгө оруулалт				
1.	5 багийн Засаг даргын мотоцикл	10.0		УИХ-ын 2016 оны 09 дүгээр 09-ний өдрийн 47 дугаар тогтоолын 2.в.6-д /төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх/,
2.	Эрдэнэдалай суманд хог зөөврийн машин	20.0		2.в.7-д /эмнэлгийн түргэн тусламж, онцгой байдал, авлигатай тэмцэх, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, прокурор, цагдаагийн эргүүл хамгаалалт, шүүхийн шинжилгээний алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хил хамгаалах, батлан
3.	Дэлгэрцогт, Өндөршил сумдын ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	100.0		

4.	АЗДТГ-ын газрын албан хэрэгцээнд автомашин	195.0	Албан хэрэгцээнд 1 авто машиныг хэт өндөр үнээр авахаар тооцоолж төсвийг үр ашиггүй зарцуулахаар төлөвлөсөн.	хамгаалах салбарын байгууллагаас бусад бүх шатны төсвийн байгууллага албан ажлын хэрэгцээнд нэгээс илүү автомашин хэрэглэхийг зогсоож, тээвэр, шатахуун, сэлбэг хэрэгсэл, үйлчилгээний бусад зардлыг бууруулах;/
5.	Хөтөлбөр арга хэмжээ	100.0	Хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээ тодорхой бус	Төсвийн тухай хуулийн 4.1.16 /“хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг/, 4.1.17 /“арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг/, 29.4. /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана./
Орон нутгийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын дүн		425.0		
Нийт хөрөнгө оруулалтын дүн		758.7		

Дээрх зөрчилтэй 758.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг жагсаалтад оруулах эсэхийг дахин хэлэлцэж Төсвийн тухай хууль, УИХ-ын баталсан 2016 оны 47 дугаар тогтоол, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журамд нийцүүлэн дахин төлөвлөж батлуулах шаардлагатай байна.

Мөн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө иргэд, сумдаас гарсан саналаас гадна аймаг хөгжүүлэх дунд хугацааны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж байх нь зүйтэй.

Аудитын газрын 2014, 2015, 2016, 2017 онд хийсэн нийцлийн аудитын тайлангаас харахад орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө

оруулалтыг үр ашигтай зохион байгуулаагүйгээс хийгдсэн зарим ажил чанарын шаардлага хангахгүй, гүйцэтгэл удаашрах, ажил чанаргүй болох, худалдан авсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй, хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт тавиагүй зэрэг зөрчлүүд жилээс жилд давтагдсаар байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) хөрөнгөөр хийгдэж буй зарим төсөл арга хэмжээнүүд иргэдийн санал аваагүй, санал асуулгаар дэмжигдээгүй, хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинжтэй олон жижиг ажил хийгдэж байгаа нь үр нөлөө багатай байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 1.2-т "ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасны үндсэн дээр иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.


Сумдад худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн дадлага туршлагатай гишүүд дутмаг байдгаас шаардлага хангахгүй оролцогчтой шууд гэрээ байгуулах, тендерийг хүчингүй болгож, тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хянаж дүгнэдэггүй, ажил гүйцэтгэх гэрээнд хүлээх хариуцлагыг тодорхой тусгаж өгөөгүйгээс гэрээний хугацаанд ажлаа хийж дуусгаагүй зөрчлүүд гарч байна.

Мөн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төсвийг нарийвчилсан тооцоо судалгаагүй хэт өндөр зардлаар төлөвлөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж байна.

Дээрх байдлаас дүгнэхэд төсвийн захирагч нар төсвийн хөрөнгийг хэтэрхий үрэлгэн, үр дүнгүй, үр ашиггүй арга хэмжээнд, хяналтгүйгээр зарцуулсаар байгаа нь харагдаж байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнг харьцуулсан судалгаа хийхэд 2014 онд 2013 оноос 8,618.9 сая төгрөгөөр өссөн, 2015 онд 2014 оноос 6,444.3 сая төгрөгөөр буурсан, 2016 онд 2015 оноос 1,413.5 сая төгрөгөөр буурсан хэдий ч өмнөх жилүүдэд гарсан алдаа зөрлүүд давтагдан гарсаар байна. /ОНХС-ийн 2014-2016 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсралт №1-т оруулав./

2013, 2014, 2015, 2016 онд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийгдсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа



Асуудал 4.2: Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа

Орон нутгийн өмчийн газар нь Орон нутгийн өмчийн албаны дүрмийн /хуучин дүрэм/ 2.13-т /*Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тухайн ТУЗ-өөр дамжуулан тогтоох, санал боловсруулж шийдвэрлүүлэх.*/ заасныг хэрэгжүүлэхгүй байгаагаас тэдгээрийн үйл ажиллагаа урсгалаар, үр ашиггүй явагдаж байна. Жич: ОНӨГ-аас шинээр батлагдсан журмыг эх хувиар ирүүлээгүй болно.

ЭЭС-уудын хувьд орон нутгийн хөрөнгийн хувь оролцоогүй тул ОНӨААТҮГ гэсэн статусаар үйл ажиллагаа явуулж байгаа нь тохиромжтой бус байгаа тул түүнийг шийдвэрлэх нь зүйтэй. Мөн ЭЭС-ийн санхүүгийн үйл ажиллагаа доголдсон, санхүүгийн тайлангийн харьцаа алдагдсан. Санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хавсралт №2-т орууллаа.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 386 дугаар тушаалаар батлагдсан “Сумын эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратеги”-ийн 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.3-т /*Эмийн эргэлтийн сангийн ажиллах журамд өөрчлөлт оруулан Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн бүртгэлийг улсын мэдэлд шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах*/-аар тусгагдсан байна. Тиймээс сумын иргэдийг зайлшгүй шаардлагатай эмээр тасралтгүй хангах төрийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх үүднээс дээр дурдсан чиглэлийг аймгуудын ИТХ-д хүргүүлэхээр шийдвэрлэсэн боловч одоог хүртэл энэ асуудал шийдэгдээгүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Өмчийн албаны дүрэм”-ийг хэрэгжүүлэн ЭЭС-ийн үйл ажиллагааны статусыг тодорхой болгох, өөрчлөх шаардлагатай байна.

Хуульд заасны дагуу сумдын ИТХ нь ОНӨААТҮГ-ыг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах эрхтэй юм.

Асуудал 4.3 Цаашид анхаарах асуудал:

1. Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой дараах заалтуудад анхаарал хандуулах нь зүйтэй. Үүнд:
 - a. 101.1.Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна.
 - b. 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.
 - c. 103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.
 - d. 103.3.Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна.
 - e. 103.4.Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

Аудитын явцад Дундговь аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш гарсан шүүхийн шийдвэрийг авч нэгтгэлээ. Шүүхийн шийдвэрээр 2016-2017 онд олгох нөхөн олговор 45.9 сая төгрөг, улсын орлогод оруулах улсын тэмдэгтийн хураамж 1.8 сая төгрөг, нийт 47.7 сая төгрөгийн шийдвэр гарсан байна.

2. Орон нутгийн өмчийн газрын тооллогоор аймгийн хэмжээнд ашиглалтгүй болон илүүдэлтэй 3.0 тэр бум төгрөгийн хөрөнгө байгаагаас дуудлага худалдаа буюу худалдан борлуулах, ашиглалтыг сайжруулах 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгө байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-т *Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд*

засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно/ мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 3.1-т / илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох/ гэсэн заалтуудыг удирдлага болгон хэрэгжүүлэх шаардлагатай. Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор батлагдсан “Дуудлага худалдаа зохион байгуулах журам”-д дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн үнэлгээг хэрхэн тогтоох талаар тусгаагүй байна.

Тав. Санал, зөвлөмж

- ✚ Дундговь аймгийн 2017 оны төсвийн төсөлд хог, хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 2018 оны төсөвт төлөвлөсөн 55.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх,
- ✚ Газрын төлбөрийг бүрэн ногдуулж, төсөвт төвлөрүүлэх,
- ✚ Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний дагуу 8 суманд шинээр баригдах барилга болон барилгын засварын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг бүрэн төвлөрүүлбэл орлого бүрдэх боломж байна;
- ✚ Шугамын түрээсийн орлогыг төвлөрүүлэх талаар тооцоо судалгаа хийж, санд төвлөрүүлэх арга хэмжээ авах;
- ✚ Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгөөр автомашин худалдан авахгүй байх шаардлагатай байна. /340.0 сая төгрөгөөр машин худалдан авахаар төлөвлөсөн нь үр ашиггүй зарцуулалт байна/;
- ✚ “Дуудлага худалдаа зохион байгуулах журам”-д дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн үнэлгээг хэрхэн тогтоох талаар тусгах;
- ✚ Эмийн эргэлтийн сангийн асуудлыг шийдвэрлэх;
- ✚ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангаж, тэдний гаргасан, дэмжигдсэн саналыг орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулан эрэмбэлж, орон нутгийн хөгжилд үр өгөөжтэй, иргэдийн амьдралд тэргүүлэх ач холбогдолтой хөтөлбөр, төсөл арга хэмжээг сонгох, сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, заавар журмын дагуу явуулж, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний бэлтгэл ажил, худалдан авах ажиллагаа, захиалагчийн хяналтыг шаардлагын хэмжээнд хэрэгжүүлэхэд ажил хариуцсан мэргэжилтнүүдийг сургаж мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажил, ажлын төсвийг нарийн тооцоо

судлагаатай, оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх замаар чанар, үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна;

- ✚ Цаашид төсвийн ил тод байдлыг хангах үүднээс Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах, төсвийн төлөвлөлт, хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгох, хууль эрх зүйгээр зохицуулсан татварыг төсөвт бүрэн оруулах арга хэмжээ авах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх, төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2017.12.01

Хавсралт 1

Орон нутгийн хөгжлийн сангийн 2014-2016 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Сумдын нэр	2014				2015				2016			
		Батлагдсан төлөвлөгөө	Олгосон санхүүжилт	2014 оны гүйцэтгэл	Үлдэгдэл	Батлагдсан төлөвлөгөө	Олгосон санхүүжилт	2015 оны гүйцэтгэл	Үлдэгдэл	Батлагдсан төлөвлөгөө	Олгосон санхүүжилт	2016 оны гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Äýeäýðóí äð	374.9	315.5	277.4	38.1	179.0	129.2	120.9	8.2	150.0	150.0	122.8	27.2
2	Äýðýí	387.7	432.2	388.3	43.9	185.5	144.5	143.2	1.3	164.4	164.4	128.6	35.9
3	Äí äü-Уäðààè	683.3	630.4	596.8	33.7	186.1	128.2	122.2	6.0	152.0	152.0	141.0	11.0
4	Öàäðàí äýeäýð	463.9	535.3	372.7	162.6	309.1	242.7	118.6	124.1	249.5	249.3	182.0	67.3
5	Äàýí äððäèàí	527.4	437.6	427.2	10.4	195.1	189.6	173.9	15.7	147.2	147.2	51.5	95.7
6	ª í äºðø èè	521.8	542.3	503.5	38.8	233.5	146.5	104.2	42.2	182.9	182.9	127.2	55.7
7	Äóðààí ñàéðàí	519.7	545.9	483.5	62.5	311.4	300.2	299.2	0.9	265.9	229.9	198.4	31.5
8	ª èçèèò	705.4	778.2	753.8	24.4	286.4	189.8	189.8	-	220.1	221.5	180.7	40.8
9	Öóèä	581.9	485.0	275.8	209.1	415.6	412.4	408.1	4.3	168.9	168.9	168.9	-
10	Ëóóñ	408.5	422.5	411.5	11.0	155.1	86.8	83.1	3.6	140.7	140.7	110.7	30.0
11	Äýeäýððàí äè	470.1	370.9	316.4	54.5	224.4	145.6	141.7	3.9	173.1	173.1	173.1	-
12	Ñàéðàí -í äí í	412.7	344.3	331.2	13.0	179.8	173.3	173.3	-	162.4	162.4	158.4	4.0
13	Ýðäýí ýààèàé	720.1	688.6	667.9	20.7	263.0	262.4	262.4	-	224.8	224.8	160.1	64.6
14	Адаацаг	503.0	417.8	401.0	16.8	182.5	143.0	143.0	-	160.3	159.9	112.5	47.5
15	Ñàéí òàäðàí	830.4	787.4	752.1	35.2	486.3	309.9	308.2	1.7	402.5	402.5	350.1	52.4
16	Аймаг	4,644.6	3,320.8	1,760.6	1,560.1	5,656.3	5,693.7	4,989.3	704.4	2,564.8	2,565.0	2,466.0	99.0
Дүн		12,755.4	11,054.6	8,719.8	2,334.8	9,448.9	8,697.4	7,781.1	916.3	5,529.5	5,494.5	4,831.9	662.6

Хавсралт 2

/мян.төг/

ЭЗС-ийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл

Д/д	Сумдын нэр	Санхүүгийн байдал						2016 оны орлого, зарлага				
		Мөнгөн хөрөнгө	Авлага	Эм, барааны үлдэгдэл	Үндсэн хөрөнгө	Үүнээс барилга	Өглөг	Борлуулалтын орлого	Нийт зардал	Үүнээс		Ашиг, алдагдал
										Цалин НДШ	Эм барааны зардал	
1	Äýëäýðöî äò	18.2	465.9	9,430.2	1,752.0		950.1	53,448.4	51,332.6	9,712.1	38,873.7	2,115.8
2	Äýðýí	891.4	11,168.4	8,689.0	3,085.3		2,722.1	66,306.4	60,473.3	7,044.9	49,095.2	5,833.1
3	Äî äü-Öäðäë	25.7	1,433.8	7,945.9	3,587.3		4,403.4	49,924.7	49,565.6	8,519.8	38,529.7	359.1
4	Цагаандэлгэр	155.2	2,695.2	2,097.7	1,931.2		12,601.6	10,896.9	15,896.7	2,092.4	9,394.8	(4,999.8)
5	Ääýí ääðäëäí	2,922.2	12,578.4	7,405.7	19,083.3	18,144.1	20,908.3	33,382.4	28,699.1	1,707.0	24,345.9	4,683.3
6	Äöðäáí ñàëöáí	213.3	308.8	4,009.7	7,030.0	4,780.6	1,365.8	52,818.4	49,587.2	8,839.2	36,328.1	3,231.2
7	ä í ä° ðø èë	32.6	195.5	6,909.4	28,807.3	24,814.5	6,070.0	61,260.7	61,302.2	11,497.3	34,954.7	(41.5)
8	ä ëçèéð	24.2	345.9	2,916.2	65,833.0	60,599.0	5,274.2	47,844.4	47,128.2	9,454.3	31,387.9	716.2
9	Ööëä	831.1	5,095.9	5,699.0	42,859.5	36,921.9	7,067.5	56,117.4	55,774.6	8,797.7	43,537.2	342.8
10	Ёóóñ	2,149.9	221.1	11,316.9	16,099.6	12,843.1	327.0	53,833.8	49,684.7	9,920.1	32,929.7	4,149.1
11	Äýëäýðöäí ääé	6,804.3	190.0	5,615.5	35,880.0	26,782.8	544.3	82,414.0	76,647.7	10,698.5	57,594.9	5,766.3
12	Ñàëöáí -î äî î	126.8	911.3	6,443.3	33,294.6	29,468.3	8,274.4	49,081.2	44,631.6	5,836.3	34,393.9	4,449.6
13	Сайнцагаан	16.9	359.7	442.9	2,109.0		6,283.8	36,697.4	38,640.9	6,802.4	30,295.1	(1,943.5)
14	Эрдэнэдалай	48.1	1,869.9	14,199.9	11,794.3	7,043.6	2,392.7	83,079.5	74,158.4	9,942.3	61,595.6	8,921.1
15	Адаацаг	2,210.5	9,553.1	10,574.9	3,372.0		2,783.9	68,727.4	66,658.5	7,444.4	52,867.2	2,068.9
	Дүн	6,470.4	47,392.9	103,696.2	276,518.4	221,397.9	81,969.1	805,833.0	770,181.3	118,308.7	576,123.6	35,651.7

ЭЭС-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл

Д/д	Сумдын нэр	Санхүүгийн байдал						2015 оны орлого, зарлага				
		Мөнгөн хөрөнгө	Авлага	Эм, барааны үлдэгдэл	Үндсэн хөрөнгө	Үүнээс барилга	Өглөг	Борлуулалтын орлого	Нийт зардал	Үүнээс		Ашиг, алдагдал
										Цалин НДШ	Эм барааны зардал	
1	Äýēäüðöî äò	34.0	190.0	7,121.4	1,752.0		522.5	39,542.4	38,611.5	8,063.4	28,471.5	930.9
2	Äýðýí	1,033.2	5,229.8	9,118.3	2,815.3		2,874.7	51,860.4	47,786.0	7,808.7	38,557.0	4,074.4
3	Äî äü-Öäääë	24.8	1,085.8	10,055.1	2,487.3		5,851.5	39,041.8	38,396.7	6,801.7	30,022.9	645.1
4	Цагаандэлгэр	Аудит хийгдээгүй										
5	Äàýí ääðäëäí	1,043.1	12,295.8	4,349.2	19,083.3	18,144.1	20,427.3	24,912.2	23,017.0	3,285.6	17,342.1	1,895.2
6	Äöðäàí ñäéðäí	152.5	441.9	4,114.6	6,865.0	4,780.6	5,686.5	39,044.1	39,259.7	9,443.7	26,325.5	(215.6)
7	^a í ä ^o ðø èë	28.9		8,090.9	28,387.3	24,814.5	7,861.8	47,188.8	50,258.7	11,497.3	34,954.7	(3,069.9)
8	^a èçèéò	46.7	835.8	4,754.3	65,973.0	60,559.0	9,979.3	29,017.9	33,354.4	10,195.6	21,812.8	(4,336.5)
9	Ööëä	28.5	190.0	9,465.0	42,584.5	36,921.9	6,462.9	47,836.3	48,271.2	10,004.0	35,748.7	(434.9)
10	Ëóóñ	351.8	221.1	8,598.7	15,634.6	12,643.1	3,502.8	35,098.2	33,325.5	9,920.1	20,913.2	1,772.7
11	Äýēäüððäí ääé	495.7	639.8	4,554.7	35,666.8	26,782.8		58,226.5	58,420.7	13,098.6	39,765.4	(194.2)
12	Ñäéðäí -Í âî î	52.0	687.6	2,175.8	33,294.6	29,468.3	8,435.1	13,691.4	17,484.1	7,872.9	8,369.5	(3,792.7)
13	Сайнцагаан	19.0	359.7	2,196.0	1,944.0		6,048.7	30,208.0	31,382.9	7,390.6	21,906.6	(1,174.9)
14	Эрдэнэдалай	28.8	2,259.2	14,518.0	12,643.8	7,043.6	11,571.1	61,022.2	59,158.5	11,013.3	45,236.1	1,863.7
15	Адаацаг	36.2	10,253.6	20,996.8	2,444.0		11,190.4	70,677.6	66,186.7	8,154.4	54,367.4	4,490.9
	Дүн	3375.2	34690.1	110108.8	271575.5	221157.9	100414.6	587367.8	584913.6	124549.9	423793.4	2454.2

